

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

№ ... 20/34

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн Үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 10 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02 тоот дүгнэлтийг үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд өөрийн хүсэлтээр чөлөөгдсөн Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдээр Монгол Улсын иргэн Болд овогтой Өлзийбаярыг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол Улсын иргэн Болд овогтой Өлзийбаяр нь Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний эрхийг 2020 оны 10 сарын 30-ны өдрөөс эхлэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол Улсын иргэн Болд овогтой Өлзийбаярт Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам болон компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
4. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар-д үүрэг болгосугай.

